



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 139.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Ховд, Эрдэнэбүрэн сум/-н ажлын тоо хэмжээнд төсөвт өртгийн зөрүү гарсантай холбогдуулан хийгдсэн ажлуудад нэмэлт гэрээ байгуулах боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Ганданповрон - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга

С.Чанцал - Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч

Б.Баярсүх - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Zax A/39 Ch

02 00103

Ц.Цэндхүү

-“Цагаан бөлбөө” ХХК-ний захирал

Нарийн бичгийн
дарга: Д.Эрдэнэбат

-Аймгийн газрын харилцаа барилга, хот
байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Тус ажилд нэмэлт гэрээ байгуулах боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн дотор багтаан гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН